



МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГАА



# “УСАНД ОСОЛДОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР”

*/Олон улсын туршлагаас/*




**Илтгэгч: Т.Олонбаяр**

*/Далайн захиргааны Усан замын тээврийн  
бүртгэл, хяналтын албаны ахлах  
мэргэжилтэн /*

# ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

## Ус хаана байна, тэнд живэх аюул бий



Усанд живж амь насаа алдах хамгийн өндөр магадлалтай насны бүлэгт 1-4 насныхан багтаж байна



## ҮЕРИЙН АЮУЛ

Хэт их хур тунадас, салхи шуургатай давалгаа, цунами болон хуй салхи



Гол, мөрөн, нуурын эрэг дагуух АРХИДАЛТ нь олон оронд усны осолд өртөх гол хүчин зүйлийн нэг байсаар байна.

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Даац хэтрүүлсэн болон техникийн шаардлага хангаагүй усан онгоцоор аялах үед



## ГОЛ БАРИМТУУД

Жил бүр  
372 000

хүн усны ослоор  
амь насаа алдаж  
байна




Үүний дийлэнх хувийг  
25-аас доош

НАСНЫ залуус болон  
бага насны хүүхдүүд  
эзэлж байна.



Усанд осолдож амь  
насаа алдсан  
эмэгтэйчүүдийн тооноос  
**эрэгтэйчүүдийн**  
тоо хоёр дахин  
их байна




Живэлт нь 1-24  
**НАСНЫХНЫ** үхлийн  
тэргүүлэх 10  
шалтгааны нэг болж  
байна.



- Буурай болон дунд орлоготой орнуудын усанд живж амь насаа алдсан иргэдийн тоог хөгжингүй орнуудынхтай харьцуулахад **зургаа** дахин их байна.
- Живэлт ихэнхдээ ил задгай усанд тохиолдож байна.

# УСНЫ ОСЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ


НАСНЫ БҮЛЭГ, БҮС НУТГААР НЬ:




Эх сурвалж: Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

## ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ ШАЛТГААН

15-аас доош насны хүүхдийн нас баралтын тоо



# УСНЫ ОСЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ



Эх сурвалж: Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

- Хамгийн бага нь 0,3/100,000 хүн Нидерланд улс
- Хамгийн өндөр хувьтай нь Зүүн өмнөд Азийн бүс нутгийн улс 10/100,000-аас дээш хүн
- Зарим бүс нутагт 39/100,000 хүн

**WORLD CONFERENCE ON DROWNING PREVENTION 2017** VANCOUVER OCTOBER 17-19

*Share Globally, Prevent Locally*

The 2019 World Conference on Drowning will take place in Durban, South Africa, 8 to 10 October

# УСНЫ ОСЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ

Усны аюул, осолд өртөмтгий хамгийн өндөр эрсдэлтэй хүн амын бүлэг, олон нийтийн дунд эрсдэлийг бууруулах зорилтот **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ\*** нэн тэргүүнд боловсруулан хэрэгжүүлэх, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн анхаарлыг хандуулах зайлшгүй шаардлагатай байна.

## \*DROWNING PREVENTION STRATEGY



- Бага насны хүүхдийн усанд живж, амь насаа алдах эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг хүүхэд бүрт хүртээмжтэй хэлбэрээр явуулж, тэднийг сурах боломжоор хангах;



- Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын түвшинд эрсдэлийн үнэлгээ, усны аюулаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөөтэй байх;



- Хувь хүний ухамсар, холбогдох байгууллагуудын хандлагыг өөрчлөх замаар усны аюул, хор хохирлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх;



- Аялал жуулчлал, усан спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН, байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь дээрх стратеги төлөвлөгөөний зорилтын нэг хэсэг гэж ойлгоно;

Эх сурвалж: Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

- Олон нийтийн дунд усны аюулаас урьдчилан сэргийлэх кампанит ажил зохион байгуулах замаар иргэдийн анхаарлыг хандуулах;
- Сургалт, семинар зохион байгуулах,
- Нийгмийн цахим сүлжээ, мэдээлэл технологийн ололтыг түлхүү ашиглах,
- Баримтад тулгуурласан мэдэгдлүүд гаргах,
- Телевизийн сувгийг ашиглан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах,
- Сурталчилгаа, сэрэмжлүүлэх хуудас, анхааруулах самбарыг оновчтой байрлалд байршуулах

Олон түвшний арга хамгийн их үр дүнтэй байдаг ба олон нийтийн оролцоог идэвхжүүлдэг.

## МОНГОЛ ДАХЬ УСНЫ ОСЛЫН МЭДЭЭЛЭЛ

- 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар усны ослын тохиолдол 18 аймгийн 56 сум, нийслэлийн 5 дүүрэгт нийт 100 удаа гарснаас 126 хүн амь насаа алдсан.
- Дээрх ослыг насны ангиллаар нь авч үзвэл:

- 0-16 нас	46
- 17-35 нас	48
- 36 дээш нас	32
- Осолдсон орчин нөхцөл:

Гол, мөрөн, нуурын усанд,	Хиймэл нуур, цөөрөмд
Гуу, жалганд тогтсон усанд	Ус зайлуулах далан, шуудуунд
- Ослын шалтгаан: анхаарал болгоомжгүй, завиар аялах, загасчлах үедээ, усанд сэлж байгаад, бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр орхисноос, гол гатлахдаа, мал услахдаа, амиа хорлосон болон согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэх мэт.

Эх сурвалж: ОБЕГ





БҮХ ОРОСЫН УСАН ДЭЭРХ  
АВРАН ТУСЛАХ НИЙГЭМЛЭГ



ОХУ нь 13 тэнгистэй хиллэдэг.  
Тус улсны нутаг дэвсгэр дээгүүр  
хамгийн том голын сүлжээ болох 2.5  
сая гаруй гол, горхи урсдаг.  
2 сая гаруй нуур, цөөрөм бий,  
Үүнээс “Байгаль нуур” нь дэлхийн  
хамгийн том цэнгэг усны нөөцөд  
тооцогддог.

- 71 бүс нутагт  
(15 бүгд найрамдах улс, 48 муж, 8  
хязгаар, 2 бие даасан тойрог, 91 хот)
- 30 гаруй мянган хүнийг сайн дурын  
үндсэн дээр ажиллуулдаг.
- Бүс нутгийн 93 салбар  
байгууллагатай

## Гол үйл ажиллагаа

- Усан дахь хүний аюулгүй байдлыг хангах;
- Хүүхэд, залуучуудын хөгжил, боловсролд анхаарах;
- Олон нийтийн амралт зугаалгын бүсүүдийг хөгжүүлэх;
- Усанд сэлэлтийн сургалт;
- Аврагчдыг сургах сургалтын төв;
- Байгаль хамгаалах;
- Сайн дурын хөдөлгөөнийг өрнүүлэх;



"Усан дахь хүний аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцооны хүрээнд ОХУ-ын усан сан бүхий амралтын бүсүүдийг хөгжүүлэх болон байгаль орчныг хамгаалах 2005-2050 хөтөлбөр"

## Наран шарлагын газрын аюулгүйн туг



- ❑ ISO TC 145/SC 1 Олон нийтийн мэдээллийн тэмдэг
- ❑ ISO 20712 Усны аюулгүй байдлын тэмдэг, наран шарлагын газрын аюулгүйн туг / багц стандарт/
- ✓ Part 1: Ажлын байр, нийтийн зориулалттай газруудын усны аюулгүйн тэмдэглэгээний тодорхойлолтууд
- ✓ Part 2: Далайн эргийн аюулгүй байдлын тугны тодорхойлолт - өнгө, хэлбэр, утга, гүйцэтгэл;
- ✓ Part 3: Ашиглалтын удирдамж


## ЗӨВЛӨМЖ

### Өөрийгөө болон дотны хүмүүсийнхээ амь насыг хамгаалахад анхаарах зүйлс:

1. Усны аюулаас хэрхэн эрсдэлгүй гарах **УР ЧАДВАРТ** суралцах;
2. Гол устай газар, орон нутгийг зорихын өмнө **ЦАГ АГААРЫН МЭДЭЭГ** урьдчилан заавал авсан байх;
3. Усанд сэлэхэд зориулсан болон **УСЧИН АВРАГЧТАЙ** газарт сэлж байх;
4. Аюулгүй байдлын болон анхааруулах бүх төрлийн **ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ,** мэдээллийн салбарын агуулгыг мөрдлөг болгох;
5. **АРХИ УУСАН ҮЕДЭЭ** ус руу орохгүй байх;
6. **АВРАХ ХАНТААЗ** хэрхэн, хэзээ ашиглах талаар мэдлэгтэй байх;
7. Усны түвшин, гүнийг хараад тодорхойлох боломжгүй үед эхлээд **ХӨЛӨӨ ДҮРЖ** үзэх, /саваа мод бусад зүйлийг ашиглах/
8. Бусдад, ялангуяа бага насны хүүхдэд усны аюулаас эрсдэлгүй гарах ур чадварт суралцахад нь **ЗӨВЛӨЖ ӨГЧ** байх;
9. Усны ойролцоо байгаа хүүхдүүдэд тавих хараа хяналтаа сайжруулж, **АНХААРЛАА СУЛРУУЛАЛГҮЙ** байх;
10. Усны ослоос бусдыг аврах, **АНХНЫ ТУСЛАМЖ**, хиймэл амьсгалыг зөв хийж сурах,



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ**



**МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГАА**

# Баярлалаа

Холбоо барих:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй  
Дүүрэг, Самбуугийн гудамж – 11, Засгийн газрийн  
XI байр, 603, 604, 611, 612 тоот

Утас: 261488, 261489, 261490, 70114801

Факс: 11-310642

Цахим хуудас: [www.monmarad.gov.mn](http://www.monmarad.gov.mn)

[www.facebook.com/monmarad](https://www.facebook.com/monmarad)

[www.twitter.com/monmarad](https://www.twitter.com/monmarad)

Цахим хаяг: [info@monmarad.gov.mn](mailto:info@monmarad.gov.mn)